

Ч.Оюунбилэг, В.Энхжаргал, Ж.Ууганцэцэг
Х.Энхжаргал, С.Баасандулам, Д.Энхжаргал

ХӨГЖИМ



Ерөнхий боловсролын сургуулийн
3 дугаар ангийн сурх бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-545

Хөгжим III: Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурх бичиг
/ Оюунбилэг Ч., ба бус; Ред. Нямсүрэн Г. - УБ. 2014.-68x

Энэхүү сурх бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурх бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-67-3

ГАРЧИГ

Алтан ном дэлгээд угтлаа	5	До эгшиг	28	Цариг цагаан ботго	54
Хотгойдын унага	6	Ре эгшиг	29	Зөв дуулахад амьсгаа чухал	55
Булигаар хүрэн цүнх	6	Фа эгшиг	30	Дуу шиг хавар	56
Ногоон дэлхийгээ аваръя	8	Тахиа	31	Түүхт хил	57
Хоёр ишиг	9	Бий биелэгээ	32	Сэтгэлд шинэгэсэн говь	57
Сүхийн цагаан морь	10	Өөрийгөө сориорой	35	Баярын жавхаа	58
Бишгүүрээр хөгжимдөх арга	11	Нарны бүжиг	39	Циркийн жүжигчин	58
Си Эгшиг	12	Мөнх тэнгэрийн орон	40	Уралдаан	59
Ля эгшиг	13	Балчир насны нөхөр	41	Уянгын аяз	59
Соль эгшиг	14	Хаврын шувуу ирлээ	42	Анхааралтай сонсоорой	59
Шувуухай	15	Төрөлх нутаг	43	Зун цаг	60
Зохицуулагч	16	Калинка	44	Хоёр нар	61
Би хөгжмийн зохиолч	18	Бүрээчин, бөмбөрчин	45	Цэцэгс	62
Өөрийгөө сориорой	20	Ми эгшиг	46	Тогоруухай	63
Цэцэгхэн	21	Ре эгшиг	47	Дэвүүрт	64
Бүүвэйн дуу	22	До эгшиг	48	Хөгжилтэй тариачин	65
Цуурай	23	Вальс	49	Хэмнэлээр тоглоё	65
Цомбон туурайтай хүрэн	25	Оцон шувуу	50	Байгаль ба хөгжим	67
Аялгуу	26	Марш	51	Өөрийгөө сориорой	68
Чардаш	27	Хургатай хонь	53		

ӨМНӨХ ҮГ

Сайн байцгаанаа уу? Хүүхдүүд ээ!

Хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе!

Хүүхдүүд та нар хөгжмийн эгшигийн өндөр нам, чанга сул, өнгө аяс, хурд, хүчийг мэдэрч, дуулж, хөгжимдөж, бүжиглэж бас хэмнэлээр хөгжимдөж сурсан.

Ямар нэг бичиг үсэггүйгээр хөгжмийг хэрхэн тэмдэглэх билээ? Иймд бид хөгжмийн эгшиг аялгууг бичиж тэмдэглэх ноот бичлэгтэй хоёрдугаар ангидаа танилцаж ноотоор дуулах гараагаа эхэлсэн.

Харин энэ удаад та нар ноотоор дуулахын зэрэгцээ бишгүүр хөгжмөөр хөгжимдөж сурна. Үүний тулд хүүхэд бүр өөрийн бишгүүр хөгжимтэй болоорой. Бишгүүр бол үлээвэр хөгжим учраас бусдад дамжуулах нь амьсгалын болон амны хөндийн эрүүл ахуйд нийцэхгүй гэдгийг анхаараарай.

Хүүхдүүд ээ! хөгжмийн сурх бичиг хүүхдүүд та нарыг өөртөө итгэлтэй, сурх, хийж бүтээх эрмэлзлэл дүүрэн, авьяаслаг сурагчид болоход хөтлөнө.

БИД ЮУ СУРАХ ВЭ?



ДУУЛЬЯ



СОНСҮЁ



ХӨГЖИМДҮЕ



БУЖИГЛЭЕ



ЗОХИОН НАЙРУУЛЬЯ

ТАНИХ ТЭМДЭГ

ДУУЛЬЯ



- Багшийгаа сонсоод дагаад дуулья.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг анхаарч дуулаарай.

Үг. Ц.Гүррагчаа

АЛТАН НОМ ДЭЛГЭЭД УГТЛАА

Ая. Б.Ганхуяг



Удаан

4

Эрд-мийг дээд - лэх Мон-гол ёс - oo Ээж аав шиг-ээ

4

дээд-лэх хувь-тай - я Аав-тай - гаа ээж-тэй - гээ Аш-дын за-я-гаа да-гаад ир -

7

хэд Ал - тан ном дэл - гээд ут - лаа

Ухааныг дээдлэх
Дээдсийн ёсоо
Ус нутаг шигээ
Хайлрах хувьтай яа

Аавтайгаа, ээжтэйгээ
Ардын сургуульд ороод ирэхэд
Ачит багш тосоод угтлаа

Номдоо мөргөх
Өвгөдийн ёсоо
Өвлөн авах
Буян заяатай яа

	<p>Аав-тай - гаа ээж-тэй - гээ</p>	<p>Мон-гол ёс - oo</p>

Монгол ардын дуугаа өвлөн дуулцгаая.




ХОТГОЙДЫН УНАГА

Дунд зэрэг

Хо - т-гой-дын у - на- га нь ээ Хон- гор хал - зан зүс - тэй дээ—
Хо - рин- тав- ны най- ран- дээр Хоо- хон- цол- ыг ол- сон юм аа

Унага насандаа уяулсан
Даага насандаа давхиулсан
Долоон хошуу наадамдаа
Долоон удаа түрүүлэв ээ

Алтан алтан амгайг нь
Амыг нь дагуулж татаарай
Ар сайхан зоог нь
Аяар аяар гуядаарай



Хо - т-гой-дын

БУЛИГААР ХҮРЭН ЦҮНХ

Сэргэлэн

Буруу - даа — дэл - тэй — у -лаанд нь
Були гаар хү рэн цүн хэнд нь

5
Мөс - нь ша -ри - гаа - д байна даа хө
Чи хэр ша -ри - гаа - д байна даа хө

Сайвар улаан моринд нь
Мөс нь шаргиад байна даа хө
Савхин хүрэн цүнхэнд нь
Чихэр шаргиад байна даа хө

Шингэн дэлтэй улаан нь
Ширгэн дээр ч байлгүй яах вэ хө
Шинэхэн найзын өвөрт нь
Чихэр ч байлгүй яах вэ хө





Дасгал 1

- Зургийн дагуу дуулж тоглоё.
- Эгшгүүдийг дэвсгэр шугамд байрлуулаарай. Үүссэн аялгуу хүүхдийн гарын хөдөлгөөнд тохирч байгаа эсэхийг шалгаарай.
- Ноотоор дуулцгаая.

The illustration shows a sequence of musical notes (Do, Do, Do, Do, Do) above a boy in a red shirt and yellow shorts, who is singing with arms outstretched. Below the notes are more musical notes (Do, Mi, Sol, Mi, Do) above another boy in a similar outfit, also singing with arms outstretched.

The illustration shows a sequence of musical notes (Do, Re, Mi, Fa, Sol, Fa) above a boy in a red shirt and yellow shorts, who is singing with arms raised. Below the notes are more musical notes (Sol, Mi, Do, Mi, Sol) above another boy in a similar outfit, also singing with arms raised.

Дасгал 2

- Ноотоор дуулцгаая.

5

The musical score consists of two staves in 2/4 time, treble clef, and a key signature of one sharp. The lyrics are written below the notes. The first staff starts with 'Bo - роо' and ends with 'и - рээ - рэй'. The second staff continues with 'Бяц - хан' and ends with 'тай'.

Bo - роо бо - роо бая - р тай Да - раа айлч - лан и - рээ - рэй

Бяц - хан Борол - дой тогло - моор байна Bo - роо бо - роо бая - р тай



СОНСҮЁ

НОГООН ДЭЛХИЙГЭЭ АВАРЬЯ

- Дурс бичлэгээ үзээрэй.



- Хөгжимд ямар ямар дүрүүд гарсан бэ?
- Аялгууны шинж төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Байгаль яагаад үнс нурам болов?
- Байгалийн сүйрлийг хөгжмөөр хэрхэн илэрхийлж байна вэ? Ярилцаарай.
- Байгалийг сэргээж амь оруулахад юу тусалсан бэ?

Хөгжмийн хэл	Хөгжмийн дүр	Мөсөн уул	Сүйрэл	Ногоон гараг
Хурд				
Хүч				
Өнгө аяс				

- “Ус амьдралыг тэтгэгч” сэдвээр гэр бүлээрээ ярилцаарай.

Хөгжим амьдралыг эгшгээр илэрхийлдэг.



ХОЁР ИШИГ

- Зургийг ажиглаад үйл явдлыг ярилцаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Эхний хэсгийн аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.
- Аялгууны эгшиглэх хүч, өнгө аяс, шинж төрх яаж өөрчлөгдсөн бэ?



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Морь, тэмээ, унаж яваа хүүхдийн хөдөлгөөнийг хөгжмийн аянд тохируулан суудал дээрээ хийцгээе.



МОРЬ

Хурдавтар



Удаавтар




ТЭМЭЭ



СҮХИЙН ЦАГААН МОРЬ (Хөгжимт үлгэр)

Б.Шарав

- Хөгжимт үлгэрээ сонсоод, зураг дээрх үйл явдлыг өгүүлэмжийн дагуу зөв дэс дараалалд оруулаарай.



- Аялгууны шинж төрх, хүч, хурдад тохирох үгийг сонгож дэвтэртээ бичээрэй.

Түгшүүртэй, намуухан, чанга, хөгжилтэй, удаан, тэмүүлэлтэй,
хүчтэй, зөвлөн, уянгалаг, бүүдгэр, энхрий, цоглог

- Сүхийн цагаан морины явдлыг хэмнэлээр тогшоорой.
- Хэмнэлээ ноотонд шилжүүлж бичээрэй.

1. Удаан


2. Удаан - аажим хурdsах



ХӨГЖИМДЬЕ



БИШГҮҮРЭЭР ХӨГЖИМДӨХ АРГА БАРИЛ



- Зүүн гараа бишгүүрийн дээд хэсэгт, баруун гараа доод хэсэгт байрлуулан зэмсгээ алдахааргүй барина.
- Биеэ чөлөөтэй байлгаж амьсгалаа гүнзгий авч жигд үлээнэ.
- Хурууны өндгөөр даралтуудын нүхийг нээж, хааж дуу авиааг үүсгэнэ.


● Даралтыг хаах



○ Даралтыг нээх



Хуруугаа дараах байдлаар байршуулаарай.



Хүүхэд бүр өөрийн бишгүүр хөгжимтэй болоорой. Бишгүүр бол үлээвэр хөгжим учраас бусдад дамжуулах нь амьсгалын болон амны хөндийн эрүүл ахуйд нийцэхгүй гэдгийг анхаараарай.



ХӨГЖИМДӨХ ДҮРЭМ

1. Ноот бичлэгийг ажиглаж хэмнэлээр тогшино.
2. Эгшгүүдийн хөдөлгөөнийг ажиглаад ноотоор аялж үзнэ.
3. Хөгжимдөхдөө хурууны дугаарыг баримтална.


СИ ЭГШИГ



Си эгшиг ноот
бичлэгт

Си - Н үсгэн тэмдэглэгээ



V - Амьсгаа авах тэмдэг



Си эгшиг
бишгүүр дээр



- Дараах дасгалыг хөгжимдөөрэй.
- Хөгжимдөхдөө дүрмээ санаарай.




ЛЯ ЭГШИГ





Ля эгшиг ноот
бичлэгт


Ля - А үсгэн тэмдэглэгээ



Ля эгшиг
бишгүүр дээр




Си - Н



Ля - А




СОЛЬ ЭГШИГ




Соль эгшиг ноот
бичлэгт

Соль - G үсгэн тэмдэглэгээ



Соль эгшиг
бишгүүр дээр



- Дасгалыг хөгжимдөхдөө зогсоцыг анхаараарай.



Дасгал 1


- Багшийн дохиог анхаарч нэгэн зэрэг жигд хэмнэлээр хөгжимдөөрэй.

5

Дасгал 2

- Дасгалыг хөгжимдөхдөө нөхдийгөө анхаарч сонсоорой.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийн хэмнэлийг сайтар анхаараарай.
- Багшийн дохиогоор нэгэн зэрэг жигд хэмнэлээр хөгжимдөөрэй.

5



БУЖИГЛЭЕ

ШУВУУХАЙ

(Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хосоороо бүжиглээрэй.



Шувуухай шувуухай шувуухай минь
Шулганан шулганан жиргэн бүжицгээ



Цэлмэг тэнгэрт наадах шиг
Цэнгэн цэнгэн дүүлэн бүжицгээ





Үг. Д.Амгалан
Ая.Б.Цэвээнсүрэн

ЗОХИЦУУЛАГЧ
(Хөгжимт хөдөлгөөн)

- “Зохицуулагч” дууны хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө гүйцэтгэж сураарай.



Энэ хотын хамгийн мундаг нь
Эрээн мод барьсан зохицуулагч байна

Гарцаар гардаггүй зарим хүмүүсийг
Ганц шүгэлдээд зогсоож байх юм



Өнөөдөр би өөдөсхөн ч гэсэн
Өндөр болохоороо зохицуулагч
болно




Томоос том болохоороо би
Толигор замын зохицуулагч болно

ЗОХИОН НАЙРУУЛЬЯ



Дасгал 1

- Зургийг ажиглаад харьцуулан ярилцаарай.
- Юу илэрхийлж байна вэ?
- Тэдгээрийн онцлог шинж төрхийг илэрхийлсэн үг бүтээж, хөдөлгөөнөөр дүрсэлж тоглоорой.
- Та нарын бүтээсэн үг хөгжмийн эгшиг, аялгууны үндсэн шинж болно.



Хөгжмийн дуу авиа

Өндөр нам

?.....

?.....

?..... эгшиглэнэ.



Дасгал 2



БИ ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ

- Зургийг ажиглаад ярилцаарай. Үйл явдлыг дүрсэлж аялгуу зохиогоорой.
- Эгшгүүдийн хөдөлгөөн хаашаа чиглэх бол!



Дасгал 3

- Зургийг ажиглаад ярилцаарай.
- Машины дуут дохиог ноотоор дүрслэн дэвсгэр шугамд бичиж тэмдэглээрэй.





Дасгал 4

- Өөрийгөө морин хуурч гэж төсөөлцгөөс.
-  ноотоор хуураа татъя. Тоолж хөгжимдөөрэй.

The illustration shows three examples of musical notation with numbered arrows indicating stroke order:

- A dotted note with a horizontal stroke: 1 2 3 4
- A solid note with a horizontal stroke: 1 2
- A solid note with a vertical stroke: 1

To the right, a cartoon boy in traditional blue clothing is playing a Morin khuur.


Ж.Дашдондог

МОРИН ХУУР

Морин хуураа татлаа
Монгол аялгуу үүслээ
Морин хуурын эгшигт
Монгол бүгдээр багтана.

Дасгал 5

- Дуулж үзээд “Маамуу нааш ир” дууны хэмнэлийг тогшоорой.
- Эгшгүүд ямар урттай байх вэ?
- Дэвтэртээ дууныхаа ноотыг гүйцээж бичээрэй.



Дасгал 6

- Оддыг зааж дуулаарай.
- Эгшгийн тоон илэрхийллийн дагуу ноотоор илэрхийлж бичээрэй.


The illustration shows a sequence of colored stars with numbers indicating a pattern:

- Two blue stars with '5' below them.
- Two pink stars with '6' below them.
- A large blue star with '5' below it.
- Two green stars with '4' below them.
- Two yellow stars with '3' below them.
- Two orange stars with '2' below them.
- A large red star with '1' below it.

Below the stars, there is musical notation on a staff with a question mark at the end.

ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Өөрийгөө төгөлдөр хуураар хөгжимдөж байна гэж төсөөлөөрэй. Ширээн дээр хурууны дугаарыг баримтлан тоглож дуулья.
- Эгшгийн тоон илэрхийлэл хурууны дугаартай тохирно.



- Өгөгдсөн хэмжээнд тохируулан гүйцээж дэвтэртээ бичээрэй.



- Ноотоо ажиглаарай. Дуулж үзээд айзам хэмжээг тодорхойлоорой.
- Хэдэн хувь байна вэ?
- Аялгууны шинж төрх, айзам хэмжээгээр нь дуу, бүжиг, маршийн аль нь болохыг тодорхойлоорой.





ДУУЛЬЯ

Үг. Д.Дарамсэд
Ая. Ц.Эрдэнэ

ЦЭЦЭГХЭН

Тайван

Хон - хон цэц - гийн дэл - бээ Хөөр хөн бид - нийг чим - лээ дээ


Хөг - жүүн хүү - хэд на - сан даа Аав - ын - хаа эн - гэрт наад - сан даа

18
Аав - аа ээж - ээ баяр - луу - лах гэж Ал - тан - зул цэц - гийг зур - сан - даа

26
Аав - аа ээж - ээ баяр - луу - лах гэж Ал - тан - зул цэц - гийг бэ - лэг лэнэ дээ


Удвал цэцгийн дэлбээ нь
Уяхан ээжийг гоёлоо доо
Уяруун хүүхэд насандаа
Ээжийнхээ өвөрт дэрвэсэн дээ

Уран цэцгийн дэлбээ нь
Үлэмж гоёхон ургана даа
Ариухан хүүхэд насандаа
Аав ээждээ эрхэлсэн дээ



дэл - бээ чим - лээ дээ наад - сан даа

Хэмнэлийн
хамсраа хийж
дуулаарай.





- Бүүвэйн дууг ямар хурдаар дуулах вэ? Зураглалаас сонгоорой.

Бүүвэйн дуу нь хүнийг тайтгаруулан тайвшруулах төдийгүй хүүхдийн өсөлт, хөгжилтөд таатай нөлөө үзүүлдэг. Бүүвэйн дуу сонсож өссөн хүүхэд өр зөөлөн, үйл хөдөлгөөн ариун, ухаан үлэмж, амар амгалан хүмүүн болдог.



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхааралтай ажиглаад багшийнхаа гарын дохиогоор эгшгийн өндрийг мэдэрч дуулаарай.

Үг. Б.Явуухулан

БҮҮВЭЙН ДУУ

Ая. Ц.Эрдэнэ

Тайван

Yy - лэн дун - даа мэл - мэр - сэн Уд-шийн са - ран нойр соо—рой
 7
 Өл-гий дун-даа тор- мой_ сон Бяц-хан үр минь нойр- соо— рой Бүү-вэй
 14
 Ээ бүү - вэй бүү-вэй Бяц-хан үр минь нойр- соо - рой

Нуугин дундаа нуугисан
Нугасны дэгдээхэй нойрсоорой

Нойрон дундаа талимаарсан
Бяцхан үр минь нойрсоорой

Бүү-вэй
ээ бүү - вэй
бүү - вэй

- Багштайгаа хамтарч ноотоор дуулаарай.



ЦУУРАЙ

Сургач

Багши

- Зургийн дагуу ярилцаарай. Юу дүрсэлсэн бэ?

- Дуулах дасгалтай холбон тайлбарлаарай.





Дасгал 1

- Ноотоор дуулцгаая.

V V

C C E G E C D D H D H G

V V

C C C E G E C G F E D C

Дасгал 2

- Ноотоор дуулцгаая.
- Ноот бичлэгийг ажиглаад зогсоцтой хэсэгт хэмнэлийн хамсраа хийгээрэй.

1

2

3

4

5

6

7

8


9



СОНСЬЁ

- Хөгжмөө анхаарч сонсоорой.
- Чавхаст хөгжмийн эгшиглэлтийг сонсож ярилцаарай.

Монгол ардын дуу
ЦОМБОН ТУУРАЙТАЙ ХҮРЭН
(Ж.Чулуун “Ардын хоёр дууны хувилбар аяз” -аас)



Босоо ятга



Хийл



Морин хийл



Аргил хийл




- Хөгжмөө анхаарч сонсоорой.
- Бусдаас илүү тод, ялгарч сонсогдож байгаа хөгжмийн зэмсгийн дуугаралт ямар байна вэ? Тохирох үгсийг сонгоорой.

Нарийн, бүдүүн, уянгалаг, эгшиглэнтэй, хүнгэнэсэн, тунгалаг, цангинасан

Ж.Мэнд-Амар

АЯЛГУУ

Монгол үндэсний хөгжмийн зэмсгүүд



Гоцлон хөгжимдсөн зэмсэг бол хуучир.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ямар ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн бэ?

В.Монте

ЧАРДАШ



- Хөгжимдөх хурдыг зураглалтай холбон ярилцаарай.



- Хурдан



- Удаан


- Зургийг ажиглаад хөгжмийн зэмсгүүд хэрхэн ээлж дараалан тоглохыг сонсоорой.






ХӨГЖИМДЬЕ

ДО ЭГШИГ



До эгшиг ноот
бичлэгт

До - С үсгэн тэмдэглэгээ



До эгшиг
бишгүүр дээр



Дасгал 1



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг ажиглаарай.
- Хөгжимдөхөд ямар хүндрэл гарч байна вэ?
- G → С эгшигт шилжиж байгаа 1, 2-р хурууны хөдөлгөөнийй давтаарай.




РЕ ЭГШИГ




Ре эгшиг ноот бичлэгт

Pe - D үсгэн тэмдэглэгээ



Ре эгшиг
бишгүүр дээр




- Эгшгийн шилжилтийг ажиглаарай.
 - Энэ хэсгийн хурууны байрлалыг давтацаа.




Дасгал 2

- Тусгайлан тэмдэглэсний учир юу вэ?






ФА ЭГШИГ



Фа эгшиг ноот
бичлэгт

Фа - F үсгэн тэмдэглэгээ



Фа эгшиг
бишгүүр дээр



Дасгал 3



Дасгал 4





БҮЖИГЛЭЕ

ТАХИА

(Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн хэмнэл, шинж төрхөд тохируулан тахианы хөдөлгөөнийг дүрслэн зохиомжилж бүжиглээрэй.



Үүрээр донгодож бүхнийг сэргэнэ.

Хүзүүгээ урагш хойш хөдөлгөн
ийш тийш алхана.



Сүүлээ хөдөлгөн хоёр тийш найгана.

Далавчаа хөдөлгөн дээш доош
сууж босно.





БИЙ БИЕЛГЭЭ

- Шударга хөгжмийн аялгуунд тохируулан хөдөлгөөнийг зөв гүйцэтгэж сураарай.



Урсгал мөнгөн горхины
Уянга эгшгээр биелнэ



Аясын цагаан салхины
Айзам эгшгээр биелнэ

ЗОХИОН НАЙРУУЛЬЯ



Дасгал 1

- Зургийн дагуу туршилт хийе.
- Туршилтаа хөгжмийн зэмсгийн зарагтай холбон ярилцаарай.



Дасгал 2

- Аль аль хөгжимчид нэг баг болох вэ?
- Туршилт дээрээ үндэслэн хөгжмийн зэмсгүүдийг бүлэглээрэй.



Үлээвэр хөгжим

Чавхдаст хөгжим

Цохивор хөгжим

Дасгал 3



- Хөгжмөө сонсоорой.
- Урт резин бэлтгээрэй.
- Хөгжимчин болж тоглоорой.





Дасгал 4

- Хүснэгтийн зүй тогтлыг ажиглаарай.
- Өгөгдсөн эгшгээс өгсөх чиглэлд цээжээр уншаарай.
- Эгшгийн цувааг ноотоор дуулаарай.

F						
E						
D						
C						
H						
A						
G	A	H	C			

Дасгал 5

- Ноотыг нэрлээрэй. Нэрлэснээ үсгээр тэмдэглээрэй.

D

Дасгал 6

- Цохивор хөгжимчдийн хамтлаг байгуулцгаая.
- Хамтлагийн бүрэлдэхүүн дэх зэмсэг тус бүрд өгөгдсөн хэмжээгээр хэмнэл зохиогоорой.
- Өөрсдийн зохиосон бүтээлээ хөгжимдье.


	$\frac{2}{4}$				гэх мэт...	
	$\frac{2}{4}$					
	$\frac{2}{4}$					
	$\frac{2}{4}$					
	$\frac{2}{4}$					

ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Дараах ноотны уртыг нэрлээрэй.



- Дараах тэмдгүүдийг нэрлээрэй.



- Дараах хөгжмийн зэмсгүүдийн нэрийг мэдэх үү? “Эрлийг сургаар олдог Эрдмийг хичээлээр сурдаг” гэдэг.

- Энэ тухай



хайгаарай.

Морин хуур

Аргил хийл

Хийл

Морин хийл

Босоо ятга

Хуучир

Ятга



ДУУЛЬЯ



- Дараах дуунуудыг ноотоор аялаад хүүхдийн дуу, ардын дууны аль нь болохыг дэвтэртээ бичээрэй.

Буруу - даа дэл - тэй у - лаанд нь

Маа - муу нааш ир ма - найд хоёу - лаа тог - льё

- Шулгийг уншаад утгыг ярилцаарай.
- Шүлгийн утга санааг илэрхийлэх аялгуу ямар шинж төрхтэй байх вэ?

Магнаг үсэгтэй тугийг
Магнай дээрээ мандуулсан юмаа хө
Мартаж болшгүй гамин чандрууг
Магад үнэнээр дарсан юм аа хө
Ай хө зээ хө
Ардын намын журамт цэргээ хө
Хувьсгалын дуу

Наашаа цаашаа найгана аа хө
Найз нь эхлээд татна аа хө
Шүүг шааг шүжиг шажиг
Шүүг шааг шүжиг шажиг
Мод мод хатуу хө
Хөрөө хөрөө хурц аа хө
Ажил хөдөлмөрийн дуу

Бөмбөр бөмбөр модонд нь
Бүргэд шувуу эргэнэ дээ
Бөөрөнхий биеийг минь өсгөсөн
Ээжийнхээ ачийг яанам бэ хө
Элбэрэл журмын дуу

Өлгийтэй бяцхан үр минь бүүвэй Өлсөөд
ижийгээ дуудав уу бүүвэй Өнөөдөр нялх
боловч үр минь бүүвэй Өсөөд баатар
болно бүүвэй
Бүүвэйн дуу

Нарлаг өндөр алтайн ууланд
Намрын хяруу унаалаа даа
Настай буурал аав минь ээ
Намайгаа хүлээж суугаа даа
Үянгын дуу

Дуу нь төрөл, хэлбэр, агуулгаараа
маш баялаг.
Дууны аялгуу шүлгийн ерөнхий
утгыг илэрхийлдэг.



- Эхлээд нэгдүгээр бадгийг, дараа нь хоёрдугаар бадгийг дуулцгаая.
- Бадаг солигдоход аялгуу өөрчлөгдсөн үү?

Тайван

Э - лэг зүрх - нээс у - я - тай Энх-рий Мон - гол ну - таг -
5
минь Э - цэг э - хээс за - я - тай Эрдэ-ний ал - тан өл - гий - минь
Элэг зүрхнээс уяатай Цэцгийн шимийг тэтгэсэн
Энхрий Монгол нутаг минь Цэнгэлийн хавар айлчлахад
Эцэг эхээс заяатай Мөрөн гол нь дуугаа дуулж
Эрдэнийн алтан өлгий минь Мөнгөн сарьдаг нь мишээдэг

Үг нь өөрчлөгдсөн боловч аялгуу нь давтагдаж байна.

- Багшийнхаа дуулахыг сонсоорой. Дууны бадаг дахилтыг харьцуулья.
- Үг, аялгуу хоёулаа давтагдсан хэсэг аль нь вэ?

Тайван

Уу - лэн дун - даа мэл - мэр - сэн Уд-шийн са - ран нойр соо - рой
7
Өл-гий дун-даа тор- мой - сон Бяц-хан үр минь нойр- соо - рой Бүү-вэй
14
Ээ бүү - вэй бүү - вэй Бяц-хан үр минь нойр- соо - рой

Бадаг

Дахилт

Бадгийн дараах хэсгийг дахилт гэдэг. Дахилтын үг, аялгуу нь өөрчлөгдхөхгүй давтагдана.



Дасгал 1

- Дараах дуунуудыг багштайгаа хамтран дуулаад дахилттай, дахилтгүй гэж ангилаарай.

Шигширгийн ай
Хумбага Боролдой хоёрын дуу
Баатар цогтын нагац
Алаг морь

Туждаа хамт явах юмсан
Өргөн Сэлэнгэ
Халуун элгэн нутаг
Сайхан хангайн буга

Дасгал 2

- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Ямар хэмжээнд бичигдсэн байна вэ?
- Энд та нарын танил аялгуу байгаа. Ноотоор нь зөв дуулаарай. Юун тухай дуу вэ?

Тайван

The musical score consists of two staves. The first staff starts with a single note followed by a series of eighth-note pairs. There are two diamond-shaped grace note markings above the notes. The second staff begins with a single note, followed by a series of eighth-note pairs, with a dynamic marking 'f' at the start.

Дасгал 3

- Ноотоор дуулъя.
- Д.Мяасүрэн “Нар наашаа сүүдэр цаашаа” дууны ноот бичлэгт ажиглалт хийж, аялгууны ижил болон ялгаатай хэсгүүдийг олж тогтоогоорой.
- Ноотоор дуулаад аялгууны чиглэлээр зураглал гаргаарай.
- Аялгуунд давталттай хэсэг байна уу?

The musical score consists of two staves. The first staff is labeled "Дунд зэрэг". It features a series of eighth-note pairs. Below the staff, lyrics are written in a mix of Cyrillic and Latin characters: "На - раа на - раа наа - шаа Сүү - дэр сүү - дэр цаа - шаа Най - заа". The second staff continues the musical pattern with similar eighth-note pairs and lyrics: "най - заа наа - шаа Нар - тай тур-вуул тог - лоё Нар - тай тур-вуул тог - лоё".



- “Нарны бүжиг” дууны тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг анхааралтай сонсож, зөв дуулаарай.
- Ноотыг ажиглаад давталттай хэсгүүдийг олж тогтоогоорой.
- Дуулахдаа амьстааны тэмдгийг анхаараарай.

Үг. Д.Батсүрэн

Ая. З.Хангал

НАРНЫ БҮЖИГ

Цоглог

Цон-хоор о - роод и - рээ - рэй Цог - той бүж - гээ хийц - гээ - ээ

Га - даа га - раад и - рээ - рэй Гал - тай бүж - гээ хийц - гээ - ээ

Най - заа най - заа на - раа той - роод Найр - сан дуу - лаад наа - даа - рай

Най - заа най - заа на - раа той - роод найр - сан дуу - лаад бү - жээ - рэй

Цэлмэг тэнгэрийн чимэг дээ
Цэнхэр одны гэрэл дээ
Цацрах туяан гартай даа
Цэнгэлийн дууны эгшиг дээ

Агаарт мандах дэнлүү дээ
Алтан дэлхийн эрдэнэ дээ
Аливааг тэтгэх шидтэй дээ
Азтай бидний хүслэн дээ

Найз аа, найз аа нараа тойроод
Найрсан дуулаад наадаарай
Найз аа, найз аа нараа тойроод
Найрсан дуулаад бүжээрэй



Үг. Д.Хүү
Ая.С.Батболд

МОНХ ТЭНГЭРИЙН ОРОН

Дунд зэрэг

6

Ал-тан га - дас од Зу-лайд гя - лал - заж Зүг чи-гийг тод-

руулж _____

Ая-лах дэл-хийг уя-раа - сан_____ Ми-ний эх о - рон_____

11


Мөнх тэн-гэ-рийн Мон- гол_____ Мөнх тэнгэ-рийн Мон- гол_____ Ми-ний эх о - рон_____

Долоон бурхан од
Тэнгэрт анивчиж
Од гаригийн заадлаар
Орчлон дэлхийг гийгүүлсэн

Цэлмэг тэнгэрийн дор
Адуу мал нь бэлчиж
Сүүн цацлаа өргөөд
Хүж дэлхийг уяраасан

Миний эх орон
Мөнх тэнгэрийн Монгол
Мөнх тэнгэрийн Монгол
Миний эх орон

- Хэмнэлийг анхаарч сонсоод үгийг зөв хуваарилж дуулаарай.



6

ал - тан га - дас од

6

зүг чи-гийг тод -

руулж _____

3

1 2 3 = 1 2 3



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг анхааралтай ажиглая.
 - Хэмнэлийн хувьд ижил болон ялгаатай хэсгүүдийг тодорхойлоорой.
 - Тухайн хэсгүүдийг дуулахдаа багшийн хөгжимдөхийг сайн сонсоорой.

Үг. Б.Чимицдорж

Ая. Ц.Нацагдорж

БАЛЧИР НАСНЫ НӨХӨР

Хөнгөн

4
Ши-рээ тал - даа шан-дас со- рих - доо Шин-жээч у - яач-ийн

7
эр-дэмд ху - вилж Бяц-хан эз-дийн- хээ_____ бод-лыг гүй - цээж

10
Ба-риа-ны га - зарт____ тод-рон ир - дэг Хүл-гийн у - дамт

Хөөр-хөн даага-нууд минь____ Хүү-хэд бид-ний дот - ны нө - хөр - дөө

Толгодын оройн сүүдэр тоолон
Тоосон дундаас сугаран нааддаг
Сайн малчны алдрыг өргөж
Салхин хурдаар холыг түүлдаг

Хүлгийн удамт
Хөөрхөн дааганууд минь
Хүүхэд бидний
Дотны нөхөр дөө

Наран ургах өглөөг зарлан
Ногоон хөндийг сэрээж янцгаадаг
Наадамч олны хайрыг булааж
Насан багын тушиг болдог



СОНСҮЁ




- Хөгжмөө анхааралтай сонсоод доорх зураглал юу илэрхийлснийг ярилцаарай.
- Хөгжмийн зохиолыг ямар бүрэлдэхүүнээр хөгжимдөж байна вэ?



ХАВРЫН ШУВУУ ИРЛЭЭ

Л.Мөрдорж



Найрал хөгжим - Оркестр
(олуулаа хөгжимдөх хамтлаг)

Найрал дуу - Хор
(олуулаа дуулах хамтлаг)

Гоцлооч - Найрал дуу, хөгжмийн хамтлагт бусдаас ялгаран дуулагч, хөгжимдөгч
Удирдаач - Найрал дуу, найрал хөгжмийг удирдах хүн.

Хүүхдийн найрал
дуучид



Эрэгтэй найрал дуучид



Эмэгтэй найрал дуучид



Холимог найрал
дуучид





ТӨРӨЛХ НУТАГ

Г.Цэрэнпил

- Анхааралтай сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлно уу.
- Дараах төрлүүдийн аль нь вэ?

а. Дуу

б. Бүжиг

в. Марш

Хөгжмийн зохиолчдын бүтээлээс янз бүрийн шинж төрхтэй маршийг сонсож болно.

Зоримог

Хөнгөн

Зоримог

Эмгэнэн гашуудсан

Огцом

Хурц

Жигд намуухан

Хүчирхэг

Жишээ нь: Жагсаалын марш, хүндэтгэлийн марш, тамирчдын марш, гашуудлын марш, баатарчуудын марш, цэргийн марш гэх мэт. Эдгээр маршийн аялгуунаас алхааны жигд хэмнэл сонсогддог.





КАЛИНКА

И.П.Ларионов

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Зохиол хэдэн хэсгээс бүтсэн бэ?
- Хэсгүүд ямар шинж төрхтэй байна вэ?
- Өөр хоорондоо юугаараа ялгарч байна вэ?
- Эгшиглэх хүчийг тодорхойлоорой.
- Хөгжмийн зохиолын хурд хэрхэн өөрчлөгдсөн бэ?

A хэсэг	Б хэсэг
?	<ul style="list-style-type: none"> - Удаан - Уянгын - Зөөлөн - Дууны шинж төрхтэй



A



B



A



B



A

- Хөгжмөө сонсоод зураглалын дагуу хэмнэлээр тогшоорой.
- Зураглалыг хэмнэлээр илэрхийлж бичээрэй.
- Хэмнэлийн зураглалын аль нь доорх аялгуунд тохирч байна вэ?

A



B



- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Амьсгаа авах тэмдэг айзмын хэд дэх хувь дээр байна вэ?
- Аялгууг ноотоор дуулахдаа тусгайлан заагласан хэсгүүдийг анхаараарай.





БҮРЭЭЧИН, БӨМБӨРЧИН

Д.Кабалевский


- Хөгжмөө анхаарч сонсоорой.
- Ноот бичлэгийг сайтар ажиглаарай.
- Бүрээчин, бөмбөрчний хөгжимдөх хэсгүүд ямар ялгаатай байна вэ?
- Бүрээчний аялгууг ноотоор дуулж, бөмбөрчний хувийг хэмнэлээр хөгжимдөцгөө.






ХӨГЖИМДЬЕ

МИ ЭГШИГ



Ми эгшиг ноот
бичлэгт

Ми - Е үсгэн тэмдэглэгээ



Ми эгшиг
бишгүүр дээр



Дасгал 1

- Дасгалыг хөгжимдөхдөө тусгайлан тэмдэглэсэн хэсгийн хурууны шилжилтийг анхаарч хөгжимдөөрэй.
- Аялгууны давталттай хэсгийг олж тэмдэглээрэй.






РЕ ЭГШИГ



Ре эгшиг ноот
бичлэгт

Ре - D үсгэн тэмдэглэгээ



Ре эгшиг
бишгүүр дээр



Дасгал 2

- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг ажиглаад хурууны дугаарыг баримтлан гартаа хэвшүүлж давтаарай.
- Хөгжимдөхөө багшийн дохиог анхаарч нэгэн зэрэг жигд хэмнэлээр гүйцэтгээрэй.



Стаккато

Эгшигийг огцом цохилттой хөгжимдөнө.




ДО ЭГШИГ



До эгшиг ноот
бичлэгт

До - С үсгэн тэмдэглэгээ




До эгшиг
бишгүүр дээр



Дасгал 3



Дасгал 4





Дасгал 5

- Хөгжимдөж үзээд ямар дуу болохыг тодорхойлоорой.
- Чиний сайн мэддэг дуу байгаа.

8

Ж.Чулун

ВАЛЬС

- Ноотоо сайтар ажиглаарай.
- Ямар хэмжээнд бичигдсэн байна вэ?
- Хөгжимдөх дүрмээ санаарай.

Энэ тэмдгийг Лига буюу нуман холбоос гэдэг.
Хоёр ноотны уртыг нийлүүлж тоглоно.

7

12

?

?



БУЖИГЛЭЕ

ОЦОН ШУВУУД (Тойрон бүжиг)

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө бусадтай нийцүүлэн хийж , хамтарч тоглоорой.



Мөр мөрөн дээрээ гараа тавьж зогсоно.

Баруун хөлийг өргөнө.



Баруун хөлийг хажуу тийш тавина.

Зүүн хөлийг өргөнө.



Зүүн хөлийг хажуу тийш тавина.

Урагшаа нэг удаа, хойшоо нэг удаа үсэрнэ.
Дахин урагшаа гурван удаа үсэрнэ.

Санамж: Нөхдийнхөө хөл дээр гишгэхээс болгоомжлоорой.



МАРШ (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн хэмнэлд тохируулан алхахдаа янз бүрийн хөдөлгөөн хийгээрэй.



Хөгжмөө сонсоорой нэг хоёр нэг хоёр
Хөлөө өргөөрэй нэг хоёр нэг хоёр

Эгнээгээ бариарай нэг хоёр нэг хоёр
Хөдөлгөөнөө давтаарай нэг хоёр нэг хоёр



Гараа тойргоор эргүүлээрэй нэг хоёр нэг хоёр
Хөлөө өргөж үсрээрэй нэг хоёр нэг хоёр




ЗОХИОН НАЙРУУЛЬЯ

Дасгал 1

- Өгөгдсөн эгшгээс зураглалын дагуу аялгуу зохиогоорой. Зохиосон аялгуугаа ноотоор дуулаарай.
- Дуулахдаа баруун гарын хурууны дугаарыг баримтлан ширээн дээр тогшоорой.


До	Ре	Ми	Фа	Соль	Ля	Си
1	2	3	4	5	6	7



Дасгал 2

- Үсгэн тэмдэглэгээг ажиглаад зэрэгцээ эгшгийг нэрлээрэй.
- Дэвтэртээ бичээд дуулаарай.

До	Ре	Ми	Фа	Соль	Ля	Си
C	D	E	F	G	A	H





ДУУЛЬЯ

Ц.Жамбалжамц

ХӨГЖИМ -ХҮНИЙ АМЬДРАЛЫН МӨНХИЙН ДАГУУЛ

Хөгжимд дургүй хүн байдаг гэвэл хэн үнэмших билээ? Ер нь хүн эхээс мэндэлсэн цагасаа хөгжим сонсож эхэлдэг. Нялх хүүхэд эхийнхээ бүүвэйн дуунд уяран өөрийн эрхгүй унтдаг билээ. Эх хүний хувьд энэ нь нялх үрээ тайвшруулах, унтуулах арга юм. Ингэж амьдралын наад захын шаардлагаас хамгийн энгийн хялбар аялгуу үүсчээ.

Хонийг тойглох, ямааг чаалах, үхрийг өөвлөх, адууг гуруйлах, тэмээг хөөслөх зэрэг нь өөр өөрийн өвөрмөц сайхан аялгуутай, тухайн үйлтэй холбогдсон шүлэгтэй байдаг. Үүний жишээ болгож хургаа голсон хонийг тойглон уярааж, хурга авахуулахад дуулдаг монгол ардын “Хургатай хонь” дууг дуулж суръя.

- Ноотоор дуулцгаая.
- Аялгууны шинж төрхийг тодорхойлж учрыг тайлбарлаарай.

ХУРГАТАЙ ХОНЬ

Хур-га-тай хонь нь Хур - гаа да-гуулд-гийм хон-гор шар—
7
ур— гаа хө-хүүлд-гийм тойг_____ тойг_____ тойг_____ тойг



Үг. Ш.Бадарч
Ая. Г.Эрдэнэчулуун



ЦАРИГ ЦАГААН БОТГО

Хөнгөн

Зу-раг ца-гаан ингэ-ний Ца риг ца-гаан бот-го-хон До-могт буу-рал тууль-сийн

Дот-роос буйл-саар ай - суй _____

Бөө-рөл-хий и - жий-гээ дуул - на Бөн - бөн бөн - бөн буйл - наа

Бөө-рөл-хий и - жий-гээ дуул - на Дэн - дэн дэн - дэн тэш - нээ

Дэл-хий-гээ эр - гэж буйл - наа Бөн - бөн бөн - бөн Бөн - бөн бөн - бөн

Бүрэг цагаан ингэний
Бөрт цагаан ботгохон
Ураг цадиг домгийг
Уйлуулж буйлсаар айсуй

Яриг цагаан ингэний
Эрх цагаан ботгохон
Хоосон буурал домгийн
Тоосон дундаас айсуй


- Дууны дараах хэсгүүдийн хэмнэл ямар ялгаатай байна вэ?
- Ялгааг зөв илэрхийлж дуулаарай.




Бөө-рөл-хий и - жий-гээ дуул - наа



Бөн - бөн бөн - бөн



Дэл-хий-гээ эр - гэж буйл - наа





ЗӨВ ДУУЛАХАД АМЬСГАА ЧУХАЛ

Дуу дуулах амархан уу?

Зарим хүүхдэд дуулах нь хүндрэлтэй байдаг. Учир нь тэд дуулахдаа дуртай газраа заримдаа бүр үгийн дунд хүртэл амьсгаа авдаг. Энэ нь аялгууны сайхныг төдийгүй дууны утгыг алдагдуулдаг. Гэтэл амьсгаа бол хамгийн чухал нь шүү дээ.

Туршаад үзье. √ амьсгааны тэмдэг.

- Дараах хоёр жишээг хоёуланг нь удаан дуулаад үзээрэй.
- Амьсгааны тэмдэг тавигдсан хэсэгт л амьсгаа авахыг анхаар.
- А, Б хувилбарыг хооронд нь харьцуулаарай.
- Ямар ялгаатай байна вэ?
- Аль нь зөв бэ? Яагаад?

a. √ Ширээ талдаа шандас сорихдоо

б. Ширээ тал ---даа шандас сорих ---- доо

Эхний хувилбар нь дууг зөв, цэвэр дуудлагатай, төгс аялгуулаг болгож байхад сүүлийн хувилбар нь дууг зохисгүй, эвгүй, бүр инээдтэй болгож байна. Ийм байдал гаргахгүйн тулд амьсгааг гүнзгий авч аажмаар жигд гаргах дасгал хийгээрэй.

Утга санааг уран илэрхийлэн зөв дуулж сурахад амьсгаа чухал үүрэгтэй.



Амьсгааны жигд зарцуулалтаар алчуурыг агаарт нэг түвшинд тогтоох дасгал хийцгээе.

Үүний тулд амьсгаагаа гүнзгий авч жигд гаргах шаардлагатай болно. Энэ дасгал амьсгааны багтаамжийг тэлэх төдийгүй амьсгааг зөв зарцуулж сурахад тусална.

Үг. Ц.Гүррагчaa
Ая. Б.Ганхуяг



ДУУ ШИГ ХАВАР

Хөнгөн

Гор-хи гэ-сээд сэт-гэлхөглө-сөн Хүү-хэд тог-лоод Хөг-жөөн нэм-сэн

Дуу— шиг Сай - хан хав - рыг Хүү-хэд бү - хэн хүс - нэ

Аяны шувууд Яргуй ургаад Хонь хургалаад
Тэнгэр чимсэн Дэлхийг гоёсон Аялгуу нэмсэн
Багачууд хөөрч Хөгшид нарлаад Малчин баярлаад
Бүжин наадсан Хууч хөөрсөн Сэтгэл тэнийсэн

Дуу шиг сайхан хаврыг Дуу шиг сайхан хаврыг
Хүүхэд бүхэн хүснэ Хүүхэд бүхэн хүснэ





СОНСЬЁ

Л.Мөрдорж

ТҮҮХТ ХИЛ


- Хөгжмийн аялгуунд хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөөрэй.
- Энэ хэмнэлд ямар хөдөлгөөн тохиромжтой вэ? Яагаад?
- Аялгууны цог жавхлантай, эрч хүчтэй шинж ямар хэмнэлээр илэрч байна вэ?
- Аялгууны шинж төрхийг илэрхийлж чадах зураглалыг сонгоорой.

Торгон хил гэдэг
Цэнхэр униарт талын минь
Цэцэгсийн түмэн түрүү юм
Цэнгэл баяр хурсан
Цэцэн ардын минь өлгий юм



www.google.mn

Ш.Дулмаа. "Торгон хил" шүлгээс




СЭТГЭЛД ШИНГЭСЭН ГОВЬ

Н.Жанцанноров

- Дараах зургийг ямар шинж төрхтэй аялгуугаар илэрхийлж болох вэ? Яагаад?
- Чиний төсөөлж буй аялгуунд дээрх зураглааас аль нь тохиромжтой вэ?
- Хөгжмөө сонсоод зурагтай холбон ярилцаарай.




www.google.mn





БАЯРЫН ЖАВХАА

- Аялгууны шинж төрхийг тодорхойлж график дүрслэлээс олж тэмдэглээрэй.
- Аль зураглал тохиромжтой вэ? Яагаад?
- Баяр хөөр, сүр жавхaa бүрдсэн аялгууны эгшиглэх хүч ямар байх вэ?
- Хөгжмийн зохиолыг ямар хурдаар хөгжимдсөн бэ?



Аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн эгшиглэлт, хөгжимдөх хурд, эгшиглэх хүч энэ бүхэн хөгжмийн зохиолын утга агуулгыг тодорхойлдог.



ЦИРКИЙН ЖҮЖИГЧИН (цувлалаас)

Д.Кабалевский

- Зохиолын хэсгүүдийг анхааралтай сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойл.
- Зургийг ажиглаад ямар хурдаар илэрхийлж болохыг ярилцаарай.
- Зохиолын дараах хэсгүүдэд тохирох хурдыг тодорхойлоорай.

- Хөгжилтэй наадаан
- Пантомимо
- Уянга

Удаан
Хурдан
Хурдавтар
Маш удаан
Эрчимтэй хурдан





- Дараах хөгжмийн зохиолуудыг харьцуулан сонсоорой. Ямар ялгаатай байна вэ?
- Аялгууг график дүрслэлээр илэрхийлнэ үү?
- Энэ хөгжмөөс чи юуг дүрслэн харж байна вэ?

Н.Жанцанноров
УРАЛДААН



УЯНГЫН АЯЗ

Г.Бирваа



www.google.mn



www.google.mn



- Хөгжмөө анхааралтай сонсоод ноот бичлэгийг ажиглаарай. Аялгууны аль хэсгийг хөгжимдсөн бэ?
- Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсөн бэ?

1a.

16.

2a.

26.

3a.

36.

ХӨГЖИМДЬЕ




Дасгал 1

- Ноотоор хөгжимдөөрэй.
- Тэмдэглэсэн хэсгийг алга ташаарай.
- Ноотны ард тавигдсан цэг ямар үүрэгтэй вэ?

- “Зун цаг” дууны ноотыг ажиглаад хамгийн дээд, доод эгшигийг тодорхойлоорой.
- Хөгжимдөхдөө тусгайлж тэмдэглэсэн хэсгийг анхаараарай.

Ая. Ц.Сүхбаатар

ЗУН ЦАГ



Энэ хэсэгт хэмнэлийг зөв мэдэрч хөгжимдөөрэй.



“Зун цаг” дууны эгшигийн багтаамж буюу цараа

Б.Цэвээнсүрэн

ХОЁР НАР




- Хоёр нар дууны хамгийн дээд, доод эгшгийг олж царааг тодорхойлоорой.



Дасгал 2


- Вальс бүжиг хэдэн хувьт хэмжээтэй вэ?
- Вальс бүжгийн аялгуу ямар шинж төрхтэй вэ?
- Дараах хэмнэлийн дасгалуудыг гүйцэтгэж зурагт тохирох хэмнэлийг сонгоорой.
- Зураг дээрээс ямар хурдыг мэдэрч байна вэ?
- Сонгосон хэмнэлээ зурагт дүрслэгдсэн хурдаар хөгжимдөөрэй.



Дасгал 3

- Өгөгдсөн хэмнэлээр хөгжимдөөрэй.
- Хэдэн хувьт хэмжээ байна вэ?





БУЖИГЛЭЕ


ЦЭЦЭГС

(Алжаал тайлах дасгал)

- Аялгууны хэмнэлд тохируулан цэцэгсийг дүрсэлж бүжиглээрэй.



Цэцэгс нахиаллаа



Цэцэгс нар өөд
харан инээж байна

Цэцэгс цоморлогоо
нээлтээ



Цэцэгс салхинд найган
ганхаж байна.



Цэцэгс хос хосоороо эргэлдэн бүжлээ





Үг.Ш.Энхбаяр
Ая.А.Балжинням

ТОГОРУУХАЙ
(Тойрон бүжгийн дуу)

Дунд зэрэг

6

Цэ-цэгт та-лын цэн-хэр того-руу - хай Цэмц-гэр дүр-тэй

6

цэр - вүү ал - хал - на Того - руу - хай того - руу - хай

11

Цам - ха - рай Цам - ха - 3 - рай





ДЭВҮҮРТ
(Хөгжимт хөдөлгөөн)

- Аялгууны хэмнэлийг мэдэрч, хөдөлгөөний шилжилтийг зөв гүйцэтгээрэй.



Гараа дээш доош өргөж буулгана.

Дэвүүрээ өргөн өлмий
дээрээ зогсоно.



Өлмий дээрээ хөнгөн
эргэлдэнэ.

Дэвүүрээ зөрүүлсэн байдлаас баруун тийш
хагас эргэн, гараа алдлана.





Эсрэг тал руу давтана.

Хөлөө зөрүүлсэн байдлаас дэвүүрээ дээш
өргөж аажмаар буулгана.



ХӨГЖИЛТЭЙ ТАРИАЧИН

- Хэмнэлээр бүжиглэцгээе. Дасгалыг гүйцэтгэхдээ цохилт хаана байгааг хэлж явбал үр дүнтэй болно.
- Хөгжмөө маш анхааралтай сонсож яваарай. Хөгжмөө дагаж аялбал бүр сайн.



ХЭМНЭЛЭЭР ТОГЛОЁ



- Хамгийн арын хүүхэд ямар нэгэн хэмнэл зохиож тогшино.
- Дараагийн хүүхэд хэмнэлийг дууриаж тогшино.
- Энэ маягаар цуваанд зогсож байгаа бүх хүүхэд хэмнэлийг өөрийн мэдэрснээрээ дууриаж тогшино. Хамгийн сүүлийн хүүхэд буюу цувааны эхэнд зогсож байгаа хүүхэд хэмнэлийг алга ташилтаар илэрхийлж тоглоно.
- Багш зөв буруу тоглосон эсэхийг шалгахын тулд давхар хянана. Хэрвээ хэмнэл алдагдсан бол хаана алдсан болохыг илрүүлж туслана.



ЗОХИОН НАЙРУУЛЬЯ


Дасгал 1

- “Нарны бүжиг”, “Мөнх тэнгэрийн орон” дууны аялгууны шинж төрхийг тодорхойлж өөрийнхөөрөө хэмнэлийн хамсраа зохиогоорой.

Нарны бүжиг



Мөнх тэнгэрийн орон



Дасгал 2

- Зураглалын дагуу аялгуу зохиогоорой.
- Зохиосон аялгуугаа нөхдөдөө дуулж сонсгоорой.

The musical score consists of a single staff in 2/4 time with a treble clef. The music starts with a quarter note followed by a half note, then continues with eighth notes. Below the staff, there are four numbered arrows (1, 2, 3, 4) pointing to specific notes or groups of notes, likely indicating steps for a marching band or similar performance.

Дасгал 3

- Марш хэдэн хувьт хэмжээнд бичигддэг вэ?
- Эгшгийн цувааг маршийн хэмнэлээр бичээд дуулаарай.



Дасгал 4

- Вальс бүжиг хэдэн хувьт хэмжээнд бичигддэг вэ?
- Эгшгийн цувааг вальс хэмжээнд бичээд дуулаарай.



БАЙГАЛЬ БА ХӨГЖИМ

(Дүрийн тоглолт)

Тоглолтын зорилго:

- Байгалийн үзэгдэл, амьтдын дүрийг бүтээх, үйл явдлыг хөгжмөөр дүрслэн илэрхийлэх, дүрд хувирч тоглох, дуулж хөгжимдөх, багаар хамтран ажиллах

1. Шөнийн нам гүм байдал. Цонхны хөшиг хаалттай, танхим харанхуй байна.
2. Үүр цайлаа. Хөгжимд Э. Григийн “Өглөө” зохиол эгшиглэнэ. Аажмаар гэгээ тусахад бүх амьтад энд тэндээс суниан эвшээсээр босно. Хүүхдүүд янз бүрийн амьтдын баг өмссөн байна.
3. Нар мандлаа. Хөгжим эгшиглэсээр байна. /Гэрлээ асаана. Цонхны хөшгийг нээнэ/
4. Шувуудын бүжиг- Хөгжимд байгалийн дуу чимээ, шувуудын жиргээ эгшиглэнэ. 2-3 цагариг тавьсан байна. Шувууд үүрнээсээ нисэн үүрээ тойрон бүжиглэнэ.
Цохивор хөгжимчид хонх, савх мод, бөмбөр, гурвалжинаар шувуудын бүжгийн аяд хэмнэлээр хамсраа хийж хөгжимдөнө. Царгил хөгжмөөр эгшгийн цувааг өгсүүлж, уруудуулахад шувууд босох суух хөдөлгөөн хийнэ.
5. Баавгай бамбарууштайгаа явж өнгөрнө. Цохивор хөгжимчид том бөмбөрөөр тэдний хүнд болхи алхааг илэрхийлж хөгжимдөнө.
6. Туулайн бөжингүүд дэгдэн харайна. Цохивор хөгжимчид ксилифоноор холын үсрэлт бүхий дүрслэл илэрхийлж хөгжимдөнө.
7. Дуу цахилгаантай бороо орлоо. Тэнгэр харанхуйлна. Хөгжимд борооны дуу чимээ явна. Цахилгаан цахиж, тэнгэр дуугарна. Цохивор хөгжимчид цан цохиж, бөмбөр нижигнүүлнэ.
8. Бороо намдлаа. Цагариг дотор мөөгний хэлбэр бүхий малгайтай хүүхдүүд суусан байна. Мөн хоёр гартаа өнгө өнгийн алчуур хумъж барьсан хүүхдүүд цохивор хөгжимчдийг гурвалжин болон ксилофоноор хөгжимдөхөд аажмаар алгаа дэлгэнэ. Энэ үед алчуур задарч цэцэг навч дэлгэрнэ.
9. Байгаль дэлхий сэргэж амьтад тойрон бүжиглэнэ. Цохивор хөгжимчид хамтран хөгжимдөнө.



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Зургийг ажиглаад ярилцаарай.
- Тэд хэдүүлээ дуулж хөгжимдөж байна вэ?



Гоцлол



?



?




?

- “Бага ангийн багшдаа баярлалаа” дуугаа бүгдээрээ дуулаарай.
- Олуулаа дуулах бүрэлдэхүүнийг юу гэж нэрлэдэг вэ?
- Хэмнэлийг ажиглаад цэгийн оронд тохирох зогсцын тэмдгийг нөхөж бичээрэй.



- Ажиглаад нэрлээрэй.
- Тэмдэгтүүдийг хэд тоолох вэ?



- Үсгэн тэмдэглэгээг ноот бичлэгт шилжүүлээрэй.

C D E F G A H